Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Мөнгөнморьт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 817,799.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,178.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,724.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 159 мэдээлэл байршуулахаас 156 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 удаагийн 132,177.1 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 242,749.0 мянган төгрөгөөр буюу 110,572.0 мянган төгрөгөөр илүү, байршуулж, 3 удаагийн 77,272.4 мянган төгрөгийн орлого, 1 удаагийн 5,874.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй байна.

### **Шийдвэрлэсэн нь:**

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал гэж заасныг үндэслэн шаардлага өгөв.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Монгол Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар”-д төсвийн зарлагыг эдийн засгийн 2 ангиллаар баталснаас шалтгаалж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Балансын дансны жагсаалт”-ын дагуу тайлагнагдаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх саналыг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

Дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Холбогдох хууль, журмын дагуу Санхүүгийн мэргэжлийн ажилтан бүхий дотоод хяналтын ажлын хэсэгт оруулж, ажиллуулах.

Худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 7 байгууллагын худалдан авалтыг 3,305.7 мянган төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1-т “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг “Гэрэлтэх бүртгэл Аудит” ХХК гүйцэтгэж, 944,604.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 813.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 7,029.8 мянган төгрөгийн албан шаардлага өгснийг Төв аймгийн Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлсэн боловч гүйцэтгэлийн үе шатанд 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй давтан гаргасан байна..

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |              | Биелэлт  |              |             |
|-----------------|------------------------|--------------|----------|--------------|-------------|
|                 | Тоо                    | Дүн          | Тоо      | Дүн          | Хувь        |
| Зөвлөмж         | 2                      | 944.604.5    | 1        | -            | 50.0        |
| Төлбөрийн акт   | 1                      | 813.2        | 1        | 813.2        | 100.0       |
| Албан шаардлага | 1                      | 7,029.8      | 1        | 7,029.8      | 100.0       |
| <b>Нийт дүн</b> | <b>6</b>               | <b>710.9</b> | <b>5</b> | <b>600.0</b> | <b>83.3</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байснаас биет тест хэрэгжүүлээгүй.

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмж, бараа материалыг орлогод авсан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,131,851.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

Үүнд: **Залруулсан алдаа:**

1. Нэр данс зөрүүтэй орлого зарлагын нийт 1,290.0 мянган төгрөгийн гүйлгээг мөнгөн хөрөнгийн орлого зарлагын журналд бүртгээгүйг;
2. Хувь хүний орлогын албан татварт шилжүүлсэн 18,867.6 мянган төгрөгийг цалингийн өглөгийн журналд бичиж, тохируулгыг хийснийг;
3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүйг;
4. Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 1,111,693.4 мянган төгрөгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасныг үндэслэн санхүүгийн тайланд залруулсан.

Аудитаар нийт 223.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 223.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Тайлант оны эцэст хувь хүний орлогын албан татварын зөрүүг тооцоолоогүйгээс 5 ажилтанд нийт 58.0 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү тооцож олгосон нь Татварын ерөнхий газрын 2019 оны А/261 тоот тушаалын хавсралтын 4.4.10-т "Тухайн тайлант жилийн 12 сард бүрэн тухайн байгууллагад харьяалагдаж ажилласан ажилтанд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.10-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг мөн хуулийн 27.10-д заасны дагуу жилийн эцэст өссөн дүнгээр тооцож, зөрүүг залруулж тайлагнана.", санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Шалгагдагч байгууллага нь үдийн цайны хүүхдийн хоолыг нормоос 165.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Монгол Улсын Засгийн газрын 237 дугаар тогтоолын 10.1.1 сургуулийн нэг хүүхэд ногдох хоолны зардлын нормативыг инфляцийн түвшин болон суралцагчийн шим тэжээлийн хэрэгцээг харгалзан жил тутам шинэчлэн батлах, 0.1.2.энэ хуулийн 10.1.1-д заасан зардал болон тухайн жилд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардагдах зардлыг төсвийн төсөлд тусгаж, хэрэгжүүлэх", 1-д Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 1500 төгрөгөөр тогтоосугай гэсэн заалтыг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## 5.2 Зөвлөмж

### Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Тайлант хугацаанд 124 төрлийн нийт 181,419.1 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.", 14.4.7-д "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг тухай бүр холбогдох байгууллагад хүсэлт илгээн бодит үнэ цэнээр бүртгэж байх

### Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх зөвлөмж өгөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | Нийт алдаа |                    | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |                    | Буруу тусган илэрхийлсэн |                 | Үүнээс     |                    |              |          | Зөвлөмж  |          |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|--------------------|-----------------------------------|--------------------|--------------------------|-----------------|------------|--------------------|--------------|----------|----------|----------|
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Тоо        | Дүн                | Тоо                               | Дүн                | Тоо                      | Дүн             | Залруулсан |                    | Залруулаагүй |          | Тоо      | Дүн      |
| Нэр данс зөрүүтэй орлого зарлагын нийт 1,290.0 мянган төгрөгийн гүйлгээг мөнгөн хөрөнгийн орлого зарлагын журналд бүртгээгүй байна.                                                                                                                                                                                                                                                                        | 1          | 1,290.0            | -                                 | -                  | 1                        | 1,290.0         | 1          | 1,290.0            | -            | -        | -        | -        |
| Хувь хүний орлогын албан татварт шилжүүлсэн 18,867.6 мянган төгрөгийг цалингийн өглөгийн журналд бичиж, тохируулгыг тайлагнаагүй.                                                                                                                                                                                                                                                                          | 1          | 18,867.6           | -                                 | -                  | 1                        | 18,867.6        | 1          | 18,867.6           | -            | -        | -        | -        |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                         | 1          | -                  | -                                 | -                  | 1                        | -               | 1          | -                  | -            | -        | -        | -        |
| Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 1,111,693.4 мянган төгрөгийг залруулаагүй байна. | 1          | 1,111,693.4        | 1                                 | 1,111,693.4        |                          |                 | 1          | 1,111,693.4        |              |          |          |          |
| <b>Дүн</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | <b>4</b>   | <b>1,131,851.0</b> | <b>1</b>                          | <b>1,111,693.4</b> | <b>3</b>                 | <b>20,157.6</b> | <b>4</b>   | <b>1,131,851.0</b> | <b>-</b>     | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                                                                                                                                      | Нийт зөрчил |              | Үүнээс        |              |                 |     |          |          |                                      |                     |                                                 |     |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|--------------|---------------|--------------|-----------------|-----|----------|----------|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
|                                                                                                                                                                         |             |              | Төлбөрийн акт |              | Албан шаардлага |     | Зөвлөмж  |          | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                                                                                                                                                                         | Тоо         | Дүн          | Тоо           | Дүн          | Тоо             | Дүн | Тоо      | Дүн      | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн |
| Тайлант оны эцэст хувь хүний орлогын албан татварын зөрүүг тооцоолоогүйгээс 5 ажилтанд нийт 58.0 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна.      | 1           | 58.0         | 1             | 58.0         |                 |     | -        | -        |                                      |                     |                                                 |     |
| Шалгагдагч байгууллага нь үдийн цайны хүүхдийн хоолыг нормоос 165.0 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.                                                               | 1           | 165.0        | 1             | 165.0        |                 |     | -        | -        |                                      |                     |                                                 |     |
| Тайлант хугацаанд 124 төрлийн нийт 181,419.1 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгээгүй байна.                                                              | 1           | -            | -             | -            |                 |     | 1        | -        |                                      |                     |                                                 |     |
| Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна. | 1           | -            | -             | -            |                 |     | 1        | -        |                                      |                     |                                                 |     |
| <b>Дүн</b>                                                                                                                                                              | <b>4</b>    | <b>223.0</b> | <b>2</b>      | <b>223.0</b> |                 |     | <b>2</b> | <b>-</b> |                                      |                     |                                                 |     |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Нийт зөрчил |                 | Үүнээс        |          |                 |                 |          |          |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----------------|---------------|----------|-----------------|-----------------|----------|----------|
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |             |                 | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |                 | Зөвлөмж  |          |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн             | Тоо      | Дүн      |
| <b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |             |                 |               |          |                 |                 |          |          |
| Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 159 мэдээлэл байршуулахаас 157 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг байршуулаагүй, 11 удаагийн 452,916,400.00 төгрөгийн орлогын гүйлгээг 750,590.2 мянган төгрөгөөр буюу 297,673,800.00 төгрөгөөр, 2 удаагийн 21,042.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг 26,604,700.00 төгрөгөөр буюу 5,562.2 мянган төгрөгөөр тус тус илүү, 22 удаагийн 330,035,900.00 төгрөгийн орлого, 6 удаагийн 50,808.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, дансны хуулгаар нотлогдохгүй болон шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх шаардлагагүй орлогын 2 удаагийн 1,055,600.00 төгрөг, зарлагын 26 удаагийн 58,615.1 мянган төгрөгийн мэдээлэл байршуулж, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 2 удаагийн 20,847.2 мянган төгрөгийн шийдвэрийг зөрүүтэй мэдээлж, 10 удаагийн шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. | 1           | 50,808.4        | -             | -        | 1               | 50,808.4        | -        | -        |
| <b>Дүн</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | <b>1</b>    | <b>50,808.4</b> | <b>-</b>      | <b>-</b> | <b>1</b>        | <b>50,808.4</b> | <b>-</b> | <b>-</b> |
| <b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |             |                 |               |          |                 |                 |          |          |
| Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Монгол Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар”-д төсвийн зарлагыг эдийн засгийн 2 ангиллаар баталснаас шалтгаалж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Балансын дансны жагсаалт”-ын дагуу тайлагнагдаагүй байна.                                                                                                                                                                                                                                                                                                           | 1           | -               |               |          | 1               | -               |          |          |

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Ерөнхий боловсролын сургууль 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |          |                 |          |          |          |                 |          |                |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|-----------------|----------|----------|----------|-----------------|----------|----------------|
| Дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна. | 1        | -               |          |          |          |                 | 1        | -              |
| Худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 7 байгууллагын худалдан авалтыг 3,305.7 мянган төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэсэн байна.                                                                                                                                                                                                                                                                              | 1        | 3,305.7         |          |          |          |                 | 1        | 3,305.7        |
| <b>Дүн</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | <b>3</b> | <b>3,305.7</b>  |          |          | <b>1</b> | <b>-</b>        | <b>2</b> | <b>3,305.7</b> |
| <b>Нийт дүн</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | <b>4</b> | <b>54,114.1</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>2</b> | <b>50,808.4</b> | <b>2</b> | <b>3,305.7</b> |